



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 1/22

Номгон

Төрийн болон орон нутгийн өмчит
байгууллагуудад ашиглагдаж байгаа
тээврийн хэрэгслийн өөрчлөлт, хөдөлгөөнд
хяналт тавих ажлын хэсэг
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 "а", "б", заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудад ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслийн өөрчлөлт, хөдөлгөөнд хяналт тавих, энэ талаарх шаардлагатай саналыг ирүүлж байх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч – Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга: Аймгийн Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

Гишүүдэд:

-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны ахлах мэргэжилтэн

-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлого хариуцсан мэргэжилтэн

-Санхүү, төрийн сангийн хэлтсийн орлогын мэргэжилтэн

-Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн


2. Аймгийн төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудад хэрэгцээтэй болон илүүдэлтэй байгаа тээврийн хэрэгслийн талаар тогтмол хяналт тавьж тухайн автомашинуудыг шаардлагатай байгууллагад шилжүүлэн эзэмшүүлэх, данснаас хасах эсэх талаарх үнэн зөв, үндэслэл бүхий саналыг улирал бүр аймгийн Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

3. Ажлын хэсэг нь үйл ажиллагаагаа явуулахдаа Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг

13059

сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд захирагдаж, төрийн болон орон нутгийн өмчийг дур мэдэн хуулиас гадуур байгууллага хооронд шилжүүлж буй байдлыг таслан зогсоож энэ төрлийн зөрчлийг тухай бүр хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Энхбаяр/-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

The image shows a square official stamp with a signature written over it. The signature is in cursive and appears to be 'D. Mönkhсайхан'. To the left of the stamp is the word 'ДАРГА' and to the right is 'Д.МӨНХСАЙХАН'.